# ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

2022 он 09 сарын 03 өдөр №97/2022 Улаанбаатар хот

## Нэг. Ерөнхий зүйл

1.1. Нэг талаас “ЭБУ Партнерс” ХХК-ийн дэргэдэх “SF Training” сургалтын төв /цаашид “гүйцэтгэгч” гэх/-г төлөөлж Сургалтын менежер Баттулга овогтой Батсуурь, нөгөө талаас “Амгалан дулааны станц” ТӨХК /цаашид “захиалагч” гэх/-г төлөөлж Гүйцэтгэх захирал Шагдарсүрэн овогтой Баянмөнх нар Иргэний хуулийн 476-480 дугаар зүйлийг үндэслэн, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2010 оны 234 дүгээр тушаалаар батлагдсан Ачаа өргөх краныг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрмийн 8.4. дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор дараах гэрээг харилцан тохиролцож байгуулав.

Ачаа өргөх краныг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрмийн шаардлагын дагуу анхан, давтан сургалтыг зохион байгуулж, шалгалт авах, мэргэжлийн үнэмлэх олгох, хугацааг сунгах ажлыг гүйцэтгэхэд гэрээний зорилго оршино.

## Хоёр. Гэрээний үнэ, төлөх нөхцөл

2.1. Захиалагч нь Ачаа өргөх краныг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрмийн дагуу зохион байгуулагдах сургалтанд хавсралт №2-д заасан нийт 21 ажилтныг Оосорлогч дохиочин болон краны операторын сургалтад хамруулж, нийт 2 000 000 (хоёр сая) төгрөгийн нэхэмжлэлийг үндэслэн шилжүүлнэ.

## Гурав. Хугацаа

3.1. Сургалтыг Амгалан Дулааны Станц ТӨХК-ийн ажлын байранд 2022 оны 09 дүгээр сарын 14-ны өдөр зохион байгуулна. Үүнд:

А. 2022 оны 09 дүгээр сарын 14-ны өдөр Оосорлогч дохиочны эрх сунгах сургалтанд 7 ажилтан, эрх олгох 5 ажилтан, гүүрэн краны операторын эрх сунгах 1 ажилтан, шанагат хүрдэн нуруулдан овоологчийн оператор 4 ажилтан эрх сунгах, манипулятор краны оператор эрх сунгах 2 ажилтан, Краны бүрэн бүтэн байдал хариуцагчийн эрх сунгах 1 ажилтан, Краны аюулгүй ажиллагаа хариуцагч эрх олгох 1 ажилтан тус тус хамрагдана.

3.2. Энэхүү гэрээ нь хоёр талын гарын үсэг зурсан өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй.

## Дөрөв. Талуудын хүлээх үүрэг

*Захиалагчийн хүлээх эрх үүрэг:*

4.1. Ажилтнуудыг сургалтанд идэвхтэй суралцах, хичээлээс хоцрох, таслах явдлыг гаргахгүй байх.

4.2. Гүйцэтгэгч шаардсанаар Захиалагчтай холбоотой мэдээ, мэдээллээр хангана.

4.3. Гэрээнд заасан хугацаанд сургалт явуулахыг Гүйцэтгэгчээс шаардана.

4.4. Сургалт явуулах байраар хангана.

4.5. Сургалтын төлбөрийг гэрээнд заасан хугацаанд шилжүүлнэ.

*Гүйцэтгэгчийн хүлээх эрх үүрэг:*

4.1. Сургалтыг батлагдсан хөтөлбөрийн дагуу чанартай зохион байгуулна.

4.2. Гүйцэтгэгч нь гэрээний Хавсралт №2-т заагдсан ажилтнуудыг анхан ба давтан сургалтанд хамруулж, сургалтын төгсгөлд шалгалт авна.

4.3. Шалгалтанд тэнцсэн ажилтнуудад мэргэжлийн үнэмлэх олгох, ба хүчинтэй хугацааг сунгах асуудлыг 7 хоногийн хугацаанд шийдвэрлэнэ.

4.4. Гэрээний төлбөрийг хугацаандаа олгохыг шаардах.

4.5. Сургалтын гарын авлагыг цахимаар хангана.

Тав. Бусад

5.1. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр энэхүү гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулсан тохиолдолд талууд нэмэлт гэрээг үндсэн гэрээнд хавсаргах ба нэмэлт гэрээ нь энэхүү гэрээний салшгүй нэг хэсэг байна.

5.2. Гэрээнд тусг1.аагүй бусад асуудлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

5.3. Гэрээний талаар харилцах албан тушаалтан:

Захиалагчийг төлөөлж: “Амгалан дулааны станц” ТӨХК-ийн Сургалт, судалгааны мэргэжилтэн Н.Пагмаа, утас: 98071123

Гүйцэтгэгчийг төлөөлж: “ЭБУ Партнерс” ХХК-ийн гүйцэтгэх захирал Б.Ууганбаяр, утас: 88012646

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

| ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ: | ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ: |
|---|---|
| “АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ш.БАЯНМӨНХ | “ЭБУ ПАРТНЕРС” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.УУГАНБАЯР |
| САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ Ө.УДВАЛ | СУРГАЛТЫН МЕНЕЖЕР Б.БАТСУУРЬ |
| ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА Б.ГАН-ОЧИР | |
| СУРГАЛТ, СУДАЛГААНЫ МЭРГЭЖИЛТЭН Н.ПАГМАА | |

Талуудын албан ёсны хаяг, байршил:

Захиалагч:
"Амгалан дулааны станц" ТӨХК
Хаяг: БЗД, 8-р хороо, УС-15-1-1
Утас: /976-11/ 77111249,
Факс: /976-11/ 77111253

Гүйцэтгэгч:
"ЭБУ Партнерс" ХХК
Хаяг: Хан Уул дүүрэг, 3-р хороо,
Хонгор апартмент
2 давхар 201 тоот
Утас: 88012646
Майл: Uuganbayar@ebu.mn

2022 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн
хамтран ажиллах гэрээний хавсралт №1

# ГҮҮРЭН КРАНЫ ОПЕРАТОР, ООСОРЛОГЧ ДОХИОЧНЫ МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

1. Сургалт 2022 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн 09 цагт Амгалан дулааны станцын Хурлын танхимд эхэлнэ.
2. Сургалт 09:30-16:00 цагийн хооронд явагдана.
3. Сургалтыг “ЭБУ Партнерс” ХХК-ийн дэргэдэх “SF Training” сургалтын төвийн багш заана.

| № | Дүрмийн нэр | Хичээл явагдах цаг |
|---|---|---|
| 1 | Өргөх механизмын тухай ерөнхий ойлголт | 1 |
| 2 | Оосорлох хэрэгслийн тухай ойлголт | 1 |
| 3 | Аюулгүй ажиллагааны талаар | 1 |
| 4 | Гүүрэн краны засвар, үйлчилгээ, аюулгүй ажиллагааны талаар | 1 |
| 5 | Үзэгдэлт дохионы тухай ойлголт | 1 |
| 6 | Механик дамжуулга | |
| 7 | Холбогдох хууль дүрэм журам | 1 |
| 8 | Тестээр шалгалт авах | |
| **Нийт цаг** | | **6 цаг** |

ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛСАН:

СУРГАЛТЫН МЕНЕЖЕР Б.БАТСУУРЬ

СУРГАЛТ, СУДАЛГААНЫ МЭРГЭЖИЛТЭН Н.ПАГМАА

2022 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн
хамтран ажиллах гэрээний хавсралт №2

**ООСОРЛОГЧ ДОХИОЧНЫ ЭРХ СУНГАХ, ОЛГОХ СУРГАЛТАНД ХАМРАГДАХ АЖИЛТНЫ НЭРС, СУРГАЛТЫН ЗАРДАЛ**

| № | Ажилтны нэрс | Албан тушаал | Нэг ажилтны сургалтын зардал | Сургалтын төрөл |
|---|---|---|---|---|
| 1 | Д.Батсүх | Вагон хөмрөгчийн машинч | 70 000 | Эрх олгох |
| 2 | Х.Сансрайдорж | Вагон хөмрөгчийн машинч | 70 000 | Эрх сунгах |
| 3 | О.Нууцболд | Вагон хөмрөгчийн машинч | 70 000 | Эрх сунгах |
| 4 | Б.Эрдэнэбаатар | Вагон хөмрөгчийн машинч | 70 000 | Эрх сунгах |
| 5 | Н.Түмэн-Өлзий | Вагон хөмрөгчийн машинч | 70 000 | Эрх сунгах |
| 6 | Б.Жаргалбаатар | Вагон хөмрөгчийн машинч | 70 000 | Эрх сунгах |
| 7 | Э.Санжаадорж | Вагон хөмрөгчийн машинч | 70 000 | Эрх сунгах |
| 8 | Ц.Баярмагнай | Вагон хөмрөгчийн машинч | 70 000 | Эрх олгох |
| 9 | Б.Болдбаатар | Зуухны тоног төхөөрөмжийн засварчин | 70 000 | Эрх сунгах |
| 10 | Б.Өлзийбат | Зуухны тоног төхөөрөмжийн засварчин | 70 000 | Эрх олгох |
| 11 | Д. Баярмагнай | Түлш дамжуулахын тоног төхөөрөмжийн засварчин | 70 000 | Эрх олгох |
| 12 | М.Од-Эрдэнэ | Түлш дамжуулахын тоног төхөөрөмжийн засварчин | 70 000 | Эрх олгох |
| **Нийт дүн** | | | **840 000** | |

## КРАНЫ ЭРХ СУНГАХ, ОЛГОХ СУРГАЛТАНД ХАМРАГДАХ АЖИЛТНЫ НЭРС, СУРГАЛТЫН ЗАРДАЛ

| № | Ажилтны нэрс | Албан тушаал | Эрх авах сургалтын нэр | Нэг ажилтны сургалтын зардал | Сургалтын төрөл |
|---|---|---|---|---|---|
| 1 | Нямдэлгэр Сайнбилэг | Автын мнженер | Краны аюулгүй ажиллагаа хариуцагч | 180 000 | Эрх олгох |
| 2 | Б.Жамсрандорж | Кранчин-жолооч | Манипулятор краны оператор-III | 100 000 | Эрх сунгах |
| 3 | Б.Эрдэнэбат | Жолооч | Манипулятор краны оператор-III | 100 000 | Эрх сунгах |
| 4 | Б.Боргил | Зуухан цехийн ашиглалтын инженер | Краны бүрэн бүтэн байдал хариуцагч | 130 000 | Эрх сунгах |
| 5 | Ч.Нямдорж | Зуухны тоног төхөөрөмжийн засварчин | Гүүрэн краны оператор-III | 130 000 | Эрх сунгах |
| 6 | Б.Батбаясгалан | Нуруулдан овоолох төхөөрөмжийн машинч буюу түлш буулгах төхөөрөмжийн машинч | Шанагат хүрдэн нуруулдан овоологчин оператор-III | 130 000 | Эрх сунгах |
| 7 | Э.Пүрэвдоржсүрэн | | | 130 000 | Эрх сунгах |
| 8 | Г.Даваахүү | | | 130 000 | Эрх сунгах |
| 9 | Г.Мөнхбаатар | | | 130 000 | Эрх сунгах |
| **Нийт дүн** | | | | **1 160 000** | |